

ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ

2025 оны 03 сарын 17-ны өдөр

№02

Улаанбаатар хот

Нэг талаас: Монгол Улсын хуулийн этгээд болох **7055121** тоот регистрийн дугаартай **"Миракл полар рэй" ХХК** (цаашид "Худалдагч" гэх), түүнийг төлөөлж Менежер ажилтай **Ө.Золзаяа**

Нөгөө талаас: Монгол Улсын хуулийн этгээд болох **9039066** тоот регистрийн дугаартай **Завхан аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний төв** (цаашид "Худалдан авагч" гэх), түүнийг төлөөлж даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч **М.Заяат** нар Монгол улсын Иргэний хуулийн 243-р зүйл болон тус хуулийн холбогдох зүйл, заалтыг удирдлага болгон дараах нөхцлийг хэлэлцэн тохиролцож, харилцан зөвшөөрснөөр энэхүү гэрээг байгуулав.

1. Гэрээний агуулга

- 1.1. Энэхүү гэрээнд заасны дагуу Худалдагч нь биет байдлын болон эрхийн доголдолгүй барааг Худалдан авагчид хүлээлгэн өгөх, Худалдан авагч нь барааг хүлээн авч гэрээнд заасны дагуу төлбөрийг төлнө.
- 1.2. Энэхүү гэрээгээр Архивын нягтаршуулсан шүүгээ 6 ширхэгийг **8,400,000₮ /Найман сая дөрвөн зуун мянган/** төгрөгөөр үнэлэн худалдаж худалдан авахаар тохиролцож байна. Барааны үнэд НӨАТ орсон болно.
- 1.3. Худалдагч бараанд холбогдох аливаа баримт бичгийг Улаанбаатар хот дотор барааны хамт, орон нутгийн худалдан авагчид барааг тээвэрлүүлэхэд хүлээлгэн өгнө.

2. Барааны чанар, баталгаат хугацаа

- 2.1. Худалдагч талын нийлүүлэх барааны чанар нь Монгол улсын стандартад нийцсэн байна.
- 2.2. Гэрээний хавсралт 1-д барааны үзүүлэлт, техникийн тодорхойлолт, нэгж үнэ, нийт үнийн мэдээллийг хавсаргасан байна.
- 2.3. Худалдагч тал Бараанд Хавсралт 2-д дурдсан баталгаа олгоно. Баталгаат хугацааг худалдан авагчид нийлүүлсэн өдрөөс эхлэн тооцно. Баталгаат засварын хугацаанд Худалдан авагчийн буруутай үйл ажиллагаанаас гарсан гэмтлээс бусад тохиолдолд худалдагч тухайн эвдрэл гэмтлийг баталгааны нөхцлийн дагуу үнэ төлбөргүй засварлаж өгнө. Баталгаат хугацаанд барааны аливаа дутагдал доголдол, гэмтлийг арилгах буюу засварлагдах боломжгүй тохиолдолд түүнтэй ижил бараагаар сольж өгнө. Засварлах хугацааг тухайн барааны баталгааны хуудсанд зааснаар тогтооно. Барааны элэгдэл, хорогдол баталгаанд хамаарахгүй.
- 2.4. Баталгаат хугацаанд тухайн барааны тээврийн зардлыг худалдан авагч тал хариуцна. Тээвэрлэх боломжгүй барааны хэвийн ажиллахгүй болсон тохиолдолд худалдагч тал худалдан авагчийн байранд очиж засвар үйлчилгээ үзүүлнэ.

3. Бараа нийлүүлэх хугацаа, төлбөр төлөх нөхцөл

- 3.1. Худалдагч барааг ажлын 5 хоногийн дотор нийлүүлнэ.
- 3.2. Худалдан авагч **8,400,000 ₮ /Найман сая дөрвөн зуун мянган/** төгрөгийг урьдчилан төлсөнөөр барааг актын хамт хүлээлгэн өгнө.
- 3.3. Үнэ нэмэгдэх, валютын ханш өөрчлөгдөх зэрэг нь энэхүү гэрээний үнийг өөрчлөх

үндэслэл болохгүй.

3.4. Гэрээний үнэд НӨАТ орсон болно.

4. Бараа хүлээлгэн өгөх, хүлээн авах

- 4.1. Худалдагч нь гэрээнд заасан барааг худалдан авагчид гэрээ хийгдсэний дараа 14 хоногийн дотор нийлүүлнэ.
- 4.2. Худалдагч гэрээнд заасан хугацаанаас өмнө барааг нийлүүлэх эрхтэй бөгөөд ингэх тохиолдолд Худалдан авагчид нийлүүлэлтийн тухай мэдэгдсэн байна.
- 4.3. Талууд барааны тоо, хэмжээ, чанарыг хуульд заасан арга ажиллагааны дагуу шалгана.
- 4.4. Худалдан авагч хүлээн авах цэг дээр барааны тоо, хэмжээ, чанар, бараа доголдолтой эсэхийг сайтар шалгаж хүлээн авах ба хүлээн авсан тухай баримт үйлдэнэ.
- 4.5. Худалдан авагч барааг хүлээн авах явцад илэрсэн доголдлыг худалдагч талд мэдэгдэж доголдлыг арилгуулна.
- 4.6. Худалдагч тал нь Бараанд чанарын шалгалт хийж шаардлагад нийцсэний дараа худалдан авагч талд зарлагын баримт, баталгааны хуудас өгнө.

5. Хөрөнгө шилжих

- 5.1. Худалдан авагч нь Актаар нэгэнт хүлээн авсан Барааны бүрэн бүтэн байдлыг дангаар хариуцах бөгөөд төлбөрийг 100% төлснөөр түүнийг ашиглах, захиран зарцуулах эрхийг Худалдагчаас түүнд олгосон гэж үзнэ.
- 5.2. Худалдсан эд хөрөнгийг худалдан авагчид шилжүүлснээр тухайн эд хөрөнгийг ашигласны үр дүнд олсон үр шим болон тухайн эд хөрөнгө тохиолдлоор устаж, гэмтсэний эрсдэл худалдан авагчид шилжинэ.
- 5.3. Худалдагч худалдсан барааг худалдан авагчийн хүсэлтээр гэрээнд зааснаас өөр газар хүргүүлэхээр илгээсэн бол тухайн эд хөрөнгийг тээвэрлэгчид, эсхүл эрх бүхий этгээдэд шилжүүлсэн үеэс худалдан авагчид үр шим, эрсдэл шилжинэ.

6. Хариуцлага, маргаан шийдвэрлэх журам

- 6.1. Худалдан авагч гэрээнд заасан барааны үнийг төлөх хугацааг 21 /хоног/ хэтрүүлбэл худалдагч нь худалдан авагчаас бараагаа буцаан авах эрхтэй. Энэ тохиолдолд төлөгдөөгүй барааны үнийн дүнгийн 20 хувийг суутгасны дараах дүнгээр худалдан авагчид үлдсэн төлбөрийг буцаан олгоно.
- 6.2. Худалдан авагч энэ гэрээний 4.1-т заасны дагуу үнийг төлөх хугацааг хэтрүүлсэн бол Талууд харилцан тохиролцож уг хугацааг сунгаснаас бусад тохиолдолд төлөөгүй үнийн дүнгийн 0.5 хувьтай тэнцэх хэмжээний алдангийг хэтрүүлсэн хоног тутамд Худалдагчид төлнө.
- 6.3. Хэрэв Худалдагч тал нь энэ гэрээний 4.1-т заасан бараа нийлүүлэх хугацааг хожимдуулсан бол Талууд харилцан тохиролцож уг хугацааг сунгаснаас бусад тохиолдолд нийлүүлээгүй барааны үнийн дүнгийн 0.5 хувьтай тэнцэх хэмжээний алдангийг хэтрүүлсэн хоног тутамд Худалдан авагчид төлнө.
- 6.4. Энэ гэрээтэй холбогдон Талуудын хооронд үүссэн аливаа санал зөрөлдөөн, маргаантай асуудлыг Талууд эв зүйгээр хэлэлцэн шийдвэрлэхийг чармайх бөгөөд ийнхүү шийдвэрлэж чадаагүй бол маргааныг шүүхээр шийдвэрлүүлнэ.

7. Бусад зүйл

- 7.1 Уг гэрээ нь Талууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.
- 7.2 Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тохиолдолд гагцхүү бичгээр үйлдэж, талууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр гэж тооцогдоно.
- 7.3 Гэрээний хавсралтууд нь түүний салшгүй бүрэлдэхүүн хэсэг мөн.
- 7.4 Гэрээнд шууд заагаагүй аливаа асуудлыг Монгол Улсын дагаж мөрдөж буй хууль тогтоомжоор зохицуулна.
- 7.5 Гэрээг 2 хувь үйлдэж, 2025 оны 03 дугаар сарын 17-ны өдөр Улаанбаатар хотноо гарын үсэг зурав.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ
ТӨЛӨӨЛЖ:

"Миракл полар рэй" ХХК-ийг
төлөөлж
Менежер ажилтай

Ө.Золзаяа

Хаяг: Улаанбаатар хот,
Чингэлтэй дүүрэг, 3-р хороо,
Тайван соёлын төв 208 тоот

ХУДАЛДАН АВАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Завхан аймгийн Ус цаг уур орчны
шинжилгээний төвийн даргын албан
үүргийг түр орлон гүйцэтгэгч

М.ЗАЯАТ

Хаяг: Завхан аймаг
Улиастай хот, Өлзийт баг

Гар утас: 8870-0320

Гар утас: 8936-9932

"Миракл полар рэй" ХХК, Багахангай аймгийн Дотоод аудитын алба
хооронд байгуулсан 2025 оны 03 сарын 17-ны өдрийн
02. тоот гэрээний **Хавсралт 1**

Худалдах барааны үнэ

	Барааны нэр	Тоо ширхэг	Нэгжийнүнэ	Нийт үнэ
1	Архивын нягтаршуулсан шүүгээ	6	1,400,000	8,400,000
НИЙТ ДҮН				8,400,000

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ
ТӨЛӨӨЛЖ:

"Миракл полар рэй" ХХК-ийг
төлөөлж
Менежер ажилтай

Ө.Золзаяа

Хаяг: Улаанбаатар хот,
Чингэлтэй дүүрэг, 3-р хороо,
Тайван соёлын төв 208 тоот

Гар утас: 8936-9932

ХУДАЛДАН АВАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Завхан аймгийн Ус цаг уур орчны
шинжилгээний төвийн даргын албан
үүргийг түр орлон гүйцэтгэгч

М.ЗАЯАТ

Хаяг: Завхан аймаг
Улиастай хот, Өлзийт баг

Гар утас: 8870-0320



“МИРАКЛ ПОЛАР РЭЙ” ХХК

202 тоот, Тайван төв байр, Урт цагааны гудамж, 3-р хороо
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, Монгол улс
Утас: +976 8936-9932
Э-шуудан: Miraclepolarray@gmail.com

**Завхан аймгийн Цаг уурын
газар**

2025.03.14 № 25/17
танай _____ -ны № _____ -т

Танилцуулга, Үнийн санал хүргүүлэх тухай

“Миракл полар рэй” ХХК нь гадаад худалдааны чиглэлээр байгууллагдаж, импортын бараа бүтээгдэхүүний БНХАУ-ын үйлдвэрүүдээс шууд захиалагчид хүргэх байнгын үйл ажиллагааг явуулж байна.

Архивын шүүгээний танилцуулга

- Шүүгээний хэмжээ: Өндөр 2м 30 см, урт 90 см, өргөн 55 см

- Тавиурын хэмжээ: Архивын шүүгээ нь 2 талдаа нэгжээ хураах боломжтой бөгөөд нэг талдаа 6 тавиур /хэмжээг нь өөрөө тохируулж тавиурыг байрлуулах боломжтой/, 2 талдаа нийт 12 тавиуртай

- Төмрийн зузааны хэмжээ: Суурь төмрийн зузаан 3.0 мм, багана төмрийн зузаан 1.5 мм, замын төмрийн зузаан 2.0 мм, хажуу ханын төмрийн 1.0 мм, дээд оройн төмрийн зузаан 1.0 мм, тавиурын төмрийн зузаан 1.0 мм,

- Үйлдвэрлэгчийн баталгаа

- ISO9001, ISO14001, OHSAS 18001 Олон улсын чанар, стандартын шаардлагыг бүрэн хангасан.

№	Хэмжээ /өндөр, өргөн, урт/	Нэг ширхэг	Зураг
1.	Архивын шүүгээ	1,400,000	

МЕНЕЖЕР:



Ө.ЗОЛЗАЯА



ДДТД : 000007055121000250318000001917298

Нэхэмжлэгч:

ТТД : 7055121

НЭР : МИРАКЛ ПОЛАР РЭЙ

Хаяг : null

Утас : 91999313,99093700

Э-Шуудан :

Банкны нэр : ГОЛОМТ БАНК

Банкны дансны дугаар : 3455184576

НЭХЭМЖЛЭХ

Хариуцагч:

ТТД : 9039066

НЭР : Завхан аймгийн ус цаг уур орчны
шинжилгээний төв

Хаяг : Монгол, Завхан, Улиастай, , 5, 3

Утас :

Гэрээний № :

Огноо : 2025-03-18 10:57:33

Төлбөр хийх хугацаа(Хоног) :

Д/д	Бараа, ажил, үйлчилгээний нэр	Код	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Бүгд үнэ
1	Архивын шүүгээ	-	ш	6.0	1,400,000.00	8,400,000.00
Бараа, ажил үйлчилгээний үнэ :						8,400,000.00
Нэмэгдсэн өртгийн албан татвар :						0.00
Нийслэл хотын албан татвар :						0.00
Нийт дүн:						8,400,000.00



Мөнгөн дүн: найман сая дөрвөн зуун мянган төгрөг

(үсгээр)

(Тамга)

Захирал :

Нягтлан бодогч :

Баталсан: Гүйлгээ батлах-2 Б.Нямосор, 2025/03/24 10:11:53



Төрийн сангийн үйл ажиллагааны
журмын 2 дугаар хавсралт
Маягт ТТ-2А

ТӨЛБӨРИЙН ХҮСЭЛТ № POR20250324101437FSOP526ZFG64Y

2025 оны 3 сарын 24 өдөр

Байгууллагын нэр: За.УЦУОШТөв н.с		Дансны дугаар		8,400,000.00
Улсын бүртгэлийн дугаар: 9039066		100090013403	Валют төрөл	
Үүргийн дугаар:			MNT	
Хүлээн авагчийн нэр: МИРАКЛ ПОЛАР РЭЙ		Дансны дугаар		
Улсын бүртгэлийн дугаар: 7055121		3455184576	Валют төрөл	8,400,000.00
Хүлээн авагчийн банк: ГОЛОМТ БАНК			MNT	
Мөнгөн дүн үсгээр: найман сая дөрвөн зуун мянган төгрөг		Ангилал		
Гүйлгээний утга: 9039066 - Завхан аймгийн УЦУОШтөв - 03-р сар Архив шүүгээ		013 - БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН САЙД		
		71408 - Ус цаг уур, орчны шинжилгээ		
		80101 - Үндсэн үйл ажиллагааны зардал		
		0000 - Санхүүжүүлэх эх үүсвэр		
		223001 - Бусад хөрөнгө		8,400,000.00
Хяналтын хуудас:				
Үндэслэх баримт бичгийн нэр		Он, сар, өдөр, дугаар		
1	Нэхэмжлэх	2025/03/18	№ 9372090022	
2	Гэрээ	2025/03/24	№ 02	

Дарга: М.Заяат

2025-03-24 10:26:45

Ерөнхий/ахлах нягтлан бодогч: Б.Нямосор

2025-03-24 10:15:35



Төрийн санд гүйлгээ хийсэн болно
Хянасан хэрэглэгч: С.Пүрэвдорж
Хянасан огноо: 2025-03-24 11:48:47
Баталсан хэрэглэгч: Р.Намжилмаа
Баталсан огноо: 2025-03-24 15:02:20
Хэвлэсэн огноо: 2025-04-02 13:17:58